



ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠰᠢᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ- 2019 оны 11-р сар



2019.12.16



ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 11 сард 1213 эх амаржиж, 1219 хүүхэд шинээр мэндэлж, 367 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 40(3.2%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 40(3.2%)-өөр тус тус буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.



Он гарсаар нялхсын эндэгдэл 9 байна.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй




Халдварт өвчний 95 7тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 301-ээр буюу 45.9 хувиар өсчээ.



Халдварт өвчний тохиолдол өсөхөд тэмбүү 53.0 хувь, заг хүйтэн 64.0 хувь, трихоминиаз 91.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ЭРҮҮЛ МЭНД


Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 11 сард




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



528 иргэн ажилд
зуучлагдан оржээ



Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 11 сарын эцэст 174 болсны 85(48.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 45(25.8%) нь шилжин суурьшсан иргэд байна.


Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 1067(85.9%) хүнээр, өмнөх сараас 359(67.3%) хүнээр тус тус буурчээ.

Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 11 сарын эцэст 544 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 528 иргэн ажилд зуучлагдан орж, 457 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Бүртгэлтэй ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр,
2019 оны 11 сард





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 11 сарын байдлаар 36850.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7426.3 (25.2%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 11 сард өмнөх оны мөн үеэс 7426.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 4760.3 (25.7%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 1126.2 (23.1%), ҮОМШӨ-ний даатгал 784.9 (25.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 539.1 (25.7%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 215.8 (25.3%) сая төгрөгөөр өссөн байна.

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 46036.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 5018.6(12.2%) сая.төгрөгөөр өссөн байна.

04



Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 34422.9 (74.8%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5239.4 (11.4%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2654.3 (5.8%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2692.2 (5.8%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1028.0 (2.2%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 11 сард нийгмийн халамжийн сангаас 25184 иргэнд 7759.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ.



ГЭМТ ХЭРЭГ



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 11 дугаар сарын байдлаар 562 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 216 хүн гэмтэж, 46 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 76(15.6%)-аар, гэмтсэн хүний тоо 92(74.8%) -оор, нас барсан хүний тоо 24(2 дахин)-өөр нэмэгдсэн байна.



Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 11(28.2%)-ээр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 6(23.1%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 42 (33.6%)-оор, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10(55.6%)-аар, авилгын гэмт хэрэг 3(75.0%)-аар, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 14(2.4 дахин)-ээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 15(4.0 дахин)-аар өсч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(1.4%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5(50.0%)-аар, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 11(68.8%)-ээр, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 17(89.5%)-аар тус тус буурчээ.




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2683.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1056.6 (69.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 1944.3 (72.5%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

МӨНГӨ, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг



↑ -Иргэдийн мөнгөн хадгаламж 10.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн

- Нэг хадгаламж эзэмшигчдэд 1553.7 мянган төгрөг ногдож байна

- Нэг хүнд дундажаар 1649.7 мянган төгрөг ногдож байна.

↓ -Хадгаламжийн үлдэгдэл 3.9% өссөн

↑ - Зээлдэгчийн тоо 9.2 хувиар өссөн

↑ - Зээлийн өрийн үлдэгдэл 7.5 хувиар өссөн




МӨНГӨ, ЗЭЭЛ

ЗЭЭЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар
2019 оны 11 сард



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр,
2019 оны 11 сард





ТӨСӨВ, САНХҮҮ



2019 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн төсөвт 68366.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 58151.4 сая төгрөг зарцуулжээ.

/2018 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүсэн орлогын дүн тусгагдаагүй/

Орон нутгийн төсвийн
орлого, сая төг

Орон нутгийн төсвийн
зарлага, сая төг

24997.4 68366.1

2018 I-XI

2019 I-XI

48960.5 58151.4

2018 I-XI

2019 I-XI

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад **0.4 хувиар буурахад**: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.6 хувиар буурсан, бусад бараа үйлчилгээний бүлэг тогтвортой байна.




Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад **4.9 хувиар өсөхөд**: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 9.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 3.3 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 4.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 6.8 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 2.6 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 2.8 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 8.7 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 3.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.





ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс,
2018-2019 оны сар бүрээр (өмнөх сар= 100)





АЖ ҮЙЛДВЭР



2019 оны 11-р сард аж үйлдвэрийн салбарт оны үнээр 188.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 13.0(6.5%) тэрбум төгрөгөөр буурлаа.



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны 11-р сард 292.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1.8(0.6%) тэрбум төгрөгөөр буурчээ.




АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбарт эзлэх хувиар



2018 он 11 сар



2019 оны 11 сар



2019 оны 08 сард өмнөх оны мөн үеэс \пунктээр\

УҮГ 0.5 ↑

ӨАА 0.2 ↑

Компани 0.7 ↓



WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
тоглоом



Валютын ханш



аппликейнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

www.dornogovi.nso.mn